

**Монгол Улсын Иргэний Ерөнхий Газар**

**болон**

**Европын Холбооны Нисэхийн Удирдах Газар**

**хоорондын**

**Нисэхийн Аюулгүй Ажиллагааны**

**болон**

**Хүрээлэн буй Орчны Хамгаалалтын талаарх Харилцан Ойлголцлын**

**Санамж Бичиг**

Монгол Улсын Иргэний Нисэхийн Ерөнхий Газар (ИНЕГ)

болон

Европын Холбооны Нисэхийн Удирдах Газар (EASA)

хоорондын

Нисэхийн Аюулгүй Ажиллагааны

болон

Хүрээлэн буй Орчны Хамгаалалтын талаарх Харилцан Ойлголцлын

Санамж бичиг

Монгол Улсын Иргэний Нисэхийн Ерөнхий Газар (ИНЕГ) болон Европын Холбооны Нисэхийн Удирдах Газар (EASA) нь,

Нисэхийн аюулгүй ажиллагааг дээшлүүлэх нийтлэг нэг ашиг сонирхолтой болохоо ИНЕГ болон EASA нь цаг ямагт санаж,

ИНЕГ болон EASA-ын хоорондын хамгийн чухал хамтын ажиллагаа бол нисэхийн аюулгүй ажиллагааг боломжоороо сайжруулах болон хүрээлэн буй орчныг илүү сайн хамгаалах арга хэмжээ авах явдал болохыг дахин бататгах,

ИНЕГ нь EASA-гийн нисэхийн аюулгүй ажиллагаа болон хүрээлэн буй орчныг хамгаалах дүрэм журам болон түүнд тавигдах шаардлагуудад суурилсан шинэ багц дүрмийг өөрийн улсад нэвтрүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээ авах,

Европ болон дэлхий нийтийг, иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны болон хүрээлэн буй орчныг хамгаалах дээд зэргийн, нийтлэг нэг стандартаар хангах EASA-гийн зорилтыг анхааралдаа авах.

Тохиролцсон зүйлс:

ИНЕГ болон EASA нь дараах салбаруудад зохих санхүүжилтийн нөөц боломжийг өргөжүүлэх, техникийн хамтын ажиллагааг бий болгож өргөтгөхөөр тохиролцов:

- Нисэхийн аюулгүй ажиллагаа болон хүрээлэн буй орчныг хамгаалах, ATM/ANS болон Аэродром/Нисэх буудал, Нисэх багийн Үнэмлэх, гэрчилгээжүүлэлт болон нислэгийн үйл ажиллагааны дүрмүүдийг боловсруулж хэрэгжүүлэх;
- Монгол Улсын иргэний нисэхийн салбарын хэрэгцээ шаардлага болон хүсэл эрмэлзэлд дүн шинжилгээ хийх;
- техникийн хамтын ажиллагааны бүх салбарт техникийн сургалт зохион байгуулах;
- техникийн хамтын ажиллагааны бүх салбарт On Job Training-OJT сургалт зохион байгуулдаг бусад байгууллагуудад богино болон урт хугацаагаар дараагийн ажилтнуудыг бэлтгэх;

- Арилжааны нисэх, Нисдэг тэрэг болон Ерөнхий зориулалтын Нисэхийн аюулгүй ажиллагааны үндэс суурийг бий болгох;
- Үндэсний Аюулгүй Ажиллагааны хөтөлбөр (SSP) болон Аюулгүй Ажиллагааны Удирдлагын тогтолцоо (SMS)

ИНЕГ болон EASA нь техникийн хамтын ажиллагааны явцын талаар хуанлийн жил тутамд 1 удаа хуралдаж, шаардлагатай гэж үзсэн салбарын бүтээн байгуулалтын талаар авч үзэж байхаар тохиролцов.

Өөрөөр заагаагүй тохиолдолд, талууд тухайн хэрэгжүүлж буй Харилцан ойлголцлын санамж бичгийн нөхцөлүүдийг хэрэгжүүлэх хүчин чармайлтыг гаргаж шаардлагатай хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэнэ. Тухайн хэрэгжүүлж буй Харилцан ойлголцлын санамж бичгийн нөхцөлүүдийг албадан хэрэгжүүлэлтийн талаар энэхүү Харилцан ойлголцлын санамж бичгийн хавсралтад тусгасан байна. Талуудын албан ёсны эрх бүхий төлөөлөгч гарын үзсэг зурснаар дээрх хавсралт нь Харилцан ойлголцлын санамж бичгийн нэг хэсэг болно.

### **Хүчин төгөлдөр болох- Нэмэлт өөрчлөлт оруулах– Дуусгавар болгох**

Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичиг нь сүүлчийн гарын үзэг зурагдсан өдөр хүчин төгөлдөр болох ба дуусгавар болох хүртэл хүчин төгөлдөр хэвээр байна.

Харилцан ойлголцлын санамж бичигт талуудын харилцан зөвшөөрснөөр зохих нэмэлт өөрчлөлт, эсхүл сайжруулалтыг хийж болно.

Аль нэг тал нөгөө талдаа бичгээр мэдэгдэл гаргаснаас хойш 30 хоногийн дотор гэрээг цуцалж болно.

Санамж бичгийг 2012 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Герман улсын Кёлн хотод англи хэл дээр хоёр хувь байгуулсан:

Европын Нисэхийн Аюулгүй Ажиллагааны Байгууллага

Ноён. Патрик Гоудоу

Гүйцэтгэх Захирал

Монгол Улсын Иргэний Нисэхийн Ерөнхий Газар

Ноён. Санжаажавын Батмөнх

Дарга